

Орон бүхний пролетарийн нар нэгдэгтүн!

АНХ ДЭГДЭЭР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Хын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 36 (2300)

1974 оны 5 дугаар сарын 9

ПҮРЭВ

АУГАА ИХ ЯЛАЛТ

Зөвлөлтийн баатарлаг ард түмэн түүний улаан арми Германы фашизмыг бут цохиж даян дэлхийд энх цагийн эхийг авчирсан 5 дугаар сарын 9-ний өдөр—аугаа их ялалтын баярыг дэлхийн шударга хүн төрөлхтөн ёслол төгөлдөр тэмдэглэдэг билээ. Зөвлөлтийн ард түмэн улаан армийн энэ их аварга ялалт нь хөрөнгөтөн фашистууд болон дайн түрэмгийллийг өдөөн дэгдээгчид сүйрэн мөхөх тавилантайг дэлхий дахинд баттай гэрчилж өгсөн юм.

Империализмын хамгийн харгис хүчин-фашистын Герман, милитарист Японы эсрэг хийсэн ширүүн тулалдаанд Зөвлөлтийн ард түмний байгуулсан түүхэн гайхамшигт ялалт нь дэлхийн империализмын ерөнхий хямралыг улам гүнзгийрүүлж байр суурийг нь үндсээр нь ганхуулав.

ЗХУ-ын түүхэн ялалтын ачаар Европ, Азийн дарлагдсан орны ард түмэн фашистын талхигдлаас ангижирч, шинэ амьдралаа цогцлон байгуулах бололцоог олсон юм.

ЗХУ-ын ард түмэн түүний баатарлаг армийн ялалт нь коммунист намынхаа мэргэн удирдлагыг хэзээ ямагт хүлээж түүнийг бат нягтаар хүрээлсэн Зөвлөлтийн хүмүүсийн эрэлхэг тэмцэл хөдөлмөр, эх оронч, интернационалч үйлсийн үр дүн юм.

Зөвлөлтийн хүмүүс фронт дээр ч, ар талд ч бүхнийг ялалтанд, бүхнийг фронтод гэсэн намынхаа дайчин уриан дор хатан зоригроор тэмцэн, хөдөлмөрлөж өөрийн дотроос олон зуун баатарлаг үйлстэнг төрүүлсэн билээ.

Аугаа эх орны дайны хүнд өдрүүдэд Монгол—Зөвлөлтийн ах дүү ард түмний мөнх найрамдал улам батжин бэхжиж ирснийг манай ард түмэн сайн мэддэг юм. Монголын ард түмэн өөрийн үнэнч хань өмөг түшиг, Зөвлөлтийн ард түмний талд дайны анхны өдрөөс эхлэн чин үнэнч байж бүхий л бололцоогоороо туслан байлаа.

Монголын ард түмний хүч хөрөнгөөр байгуулагдсан «Хувьсгалт Монгол» танкийн цуваа, «Монгол ард» нисэх онгоцны эскадрилийнхэн аугаа эх орны дайнд хүн төрөлхтний заналт дайсан фашист Германыг бүрмөсөн устгах ариун үйлсэд манай ард түмний хүсэл зоригийг биелүүлж идэвхтэй оролцсон юм. Хөрөнгөтнүүдийн таамаглаж байснаас хэдэнараа дахин богино хугацаанд Зөвлөлтийн аугаа ард түмэн дайны хохирол хүнд их шарх сорвийг арилгаж нийгмийн янз бүрийн байгуулалттай улс орнууд энх тайвнаар зэрэгцэн оршиж энх тайвны үйлсэд болон эдийн засгийн талаар хийх уралдаандаа үлэмжийн их амжилт олж байна.

Ялангуяа өөрийн дайчин манлай коммунист намынхаа 24-рх урхлын шийдвэр IX таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө Зөвлөлтийн ард түмний өрнүүлж байгаа хамтын бадрангуй хөдөлмөр нь аварга шинэ амжилтад хүрч байна.

Үүний үр дүнд Зөвлөлтийн эдийн засаг, соёл шинжлэх ухааны хөгжил, батлан хамгаалах хүчин чадлын түвшин дээшилж дэлхийн шударга хүн төрөлхтний итгэл найдварыг бүрэн дүүрэн биелүүлэхэд шийдвэрлэх нөлөө үзүүлэх өндөр чадвар Зөвлөлтийн зэвсэгт хүчинд төгс бүрджээ.

Одоо дэлхийн аль ч өнцөгт хоромхон зуур хүрч чадах стратегийн пуужин, хүчирхэг цэнэгүүд болон хамгийн өндөр хол нисэх дуунаас хэд дахин давуу хурдтай нисэх онгоц, усан доогуур удаан хугацаагаар явж чадах атомын хөдөлгүүрт шумбадаг завь зэргээр хангагджээ.

Өнөөдөр шинэ дайны бэлтгэлээр улайран хөөцөлдөж байгаа харгис хүчнийг хязгаарлаж байхын тулд социалист хамтын нөхөрлөлийн орнууд өөрийн зэвсэгт хүчнийг бүхий л талаар бэхжүүлж Варшавын гэрээний орнуудын зэвсэгт хүчний хамтын ажиллагаа өргөжиж энэ нь Европод төдийгүй дэлхий дахины энх тайвныг цаашид улам бэхжүүлэн батжуулахад чухал нөлөө үзүүлж байна.

Орчин үед Зөвлөлтийн ард түмэн, түүний баатарлаг улаан армийн дайчид даян дэлхийн энх тайвны бат цайз найдвартай түшиг тулгуур болсоор байна.

Хөдөлмөрийн цуваа

Бүрэн сумын 8 жилийн дунд сургуулийн захиргаа пионерийн бүлгэмээс Интернационал сарын ажлын нэрэмжит нэг өдрийн бүтээл хөдөлмөрийн цуваа гаргаж ахлах ангийн сурагчид шөф нэгдлийнхээ Булангаа бригадад очиж ямаа самнаж, адуу хөөвөрлөв.

Энэ цуваагаар багш Цэрэнпэл, Жанчивсүрэн нарын хариуцсан эмэгтэй сурагчдын хөдөлмөрийн цуваа 320 гаруй ямаа самнаж 101,5 кг ноолуур авлаа. Ямаа самнах ажилд сурагч Цэрэннадмид, Хишигмаа, Б. Хоролжав, Нэргүй, Цэндсүрэн, Дуламсүрэн нар бусдаасаа идэвхтэй оролцож, нэг ямаанаас авах ноолуурыг 50—150 граммгаар давуулж 100 хувь нэгдүгээр зэрэгт тушаав.

С. НЯМДАВАА

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРАЛ ХУРАЛДАХАД 21 ХОНОГ ҮЛДЛЭЭ

ХАВРЫН ХАГАЛГАА

Тус аймгийн САА, ТАА, ХАА-н нэгдлүүд тэргүүний тариаланчдын улсын зөвлөлгөөний шийдвэрийг хэрэгжүүлэн атар газар эзэмшсэний 15 жилийн ойг угтаж хаврын хагалгааг ажлын 17—18 хоногт дуусгах хөдөлгөөн өрнүүлэн өндөр бүтээлийн 10 хоног зохион үр тарианы 11 тасаг, 62 бригад, 119 салаа социалист уралдаанд нэмэлт үүрэг аваад ажиллаж байна.

Аймгийн хэмжээгээр 60-аад мянган га газрыг хавар хагалж тариалахаар техник хүн хүчний хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулж техникчдын ажлын цаг ашиглалтыг нягтруулж хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн нэг тракторын гүйцэтгэх ажлын хэмжээ урьд жилдүүдээс үлэмж нэмэгдэж байгааг зохицуулан ихэнх газар трактор агрегат нэг бүрийг ээлжийн жолоочтой болгосон нь хаврын хагалгааг шуурхай явуулахад ач холбогдолтой болжээ. Аймгийн хэмжээгээр хаврын хагалгаанд 476 агрегат гарч өдөрт 3200—3500 га газар хагалж

байна. Хаврын хагалгааг чанартай явуулахын тулд Жаргалант, Угтаал, Эрдэнэсант, Өндөрширээт сумд тэргүүний тракторчдын туршлагыг дэлгэрүүлэх үндсэн дээр уран хагалгааны уралдаан, үзүүлэх сургууль зохиож талбайн соёлжилтыг сайжруулан талбайг тэгш жигд байлгах зорилгоор хагалгааг салхины чиглэлийн эсрэг хөндлөн явуулж тууш борнойдох арга хэмжээ авчээ.

Хаврын хагалгаанд бэлтгэл зохион байгуулалт сайтай орж ажилласан Баянцогт, Угтаал, Жаргалантын САА, Эрдэнэсант, Архустын ТАА, Лүн сумын Энхтууд, Өндөрширээт сумын Хөгжил нэгдэл эхний долоо хоногийн төлөвлөгөөг 103—110 хувь биелүүлж 20 мянга гаруй га газар хагалж борнойдож булдаад байна. Баянцогт, Угтаалын САА атрын 15 жилийн ойн нэрэмжит бригад салааг зохион байгуулан социалист уралдаанд нэмэлт үүрэг авахуулж хаврын хагалгаанд 56—100

сүү сааж нэгдэлд тушаана.

—Тэмээн сүргийн хариулга маллагаанд байнгын хяналт тавьж ажиллахаас гадна тэмээчдийн зөвлөлгөөнийг 2-оос доошгүй удаа хийлгэж тэмээг байнгын хариулгатай болгож энх сүрэгтэн суурийг бий болгоно.

—Тэмээ сургах, ноосдох ажилд залуучуудын нэгдсэн бригадыг үе үе ажиллуулж, тэмээгээр жин тээж бүтээл цуваа зохион байгуулна.

—Дундговь аймгийн Өлзийт сумын тэмээчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д. Цэндийн туршлагыг тэмээний суурийн ахлагчдыг очуулж судлуулан ажилдаа нэвтрүүлнэ.

—Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангахад онцлон анхаарч, шилмэл буур тавих, ноос, үс сайтай тэмээгээр шилмэл суурь нэгийг байгуулна.

—Тэмээг тэжээх ботгыг гардан бойжуулахад зориулж 1975 онд тэмээний хашаа нэгийг залуучуудын хүчээр барина.

—Тэмээн сүргийн дотор ашиг шимийн хяналтыг жил бүр явуулан шалгарах өндөр ашиг шимт рекорд тогтоон тусгай үнэмлэх шагналыг олгож байна.

Дэлгэрхаан сумын ХЗЭ-ийн гишүүд, залуучууд

Дэлгэрхаан сумын ХЗЭ-ийн байгууллага гишүүд, залуучуудаас тэргүүний тэмээчдийн улсын зөвлөлгөөн угтаж гаргасан УРИАЛГА

Ш. ЦЭРЭНДОО

АЙМГИЙН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЗӨВЛӨЛД

Аймгийн худалдаа бэлтгэлийн 1974 оны төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тулд социалист уралдааныг эрчимтэй өрнүүлэх тухай хэлэлцээд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл хавсарсан тогтоол гаргалаа.

Уг тогтоолд аймгийн ХБҮГ, сумдын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл, ХБА-иудад үүрэг, болгохдоо:

—Худалдаа бэлтгэлийн ажлын эдийн засгийн чанарын үзүүлэлтийн гол хүчин зүйл хөдөлмөрийн бүтээмжийг өнгөрсөн оныхоос 6,3 хувь дээшлүүлж худалдаа бэлтгэлийн ажлын хөдөлмөрийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулан боловсронгуй болгох.

—Худалдаа нийтийн хоолны тоног төхөөрөмжийн хүчин чадлын ашиглалтыг өнгөрсөн оныхоос 20-иос доошгүй хувиар нэмэгдүүлэх.

—Барaa бэлтгэл, нийтийн хоолны зардлыг хямдруулан ашигт ажиллагааны түвшинг 3,3 хувьд хүргэж, мал тууврын зүй бус хорогдлыг сүүлийн 3 жилийн дунджаас 45 хувиар, түүхий ад бэлтгэлийн чанарын дарагдлыг өнгөрсөн оныхоос 50 хувиас доошгүйгээр тус тус хорогдуулах.

—Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг эрс сайжруулан одоогийн байгаа найдвартай өр авлагыг бүрэн хурааж, 1974 оны эхэнд байсан дутагдал шамшигдлын өрийг ХБА ба ХБҮГ-ын хэмжээгээр 40 хувиар хорогдуулах.

—Худалдаа бэлтгэлийн байгууллагуудын ажилтан, ажилчдын мэдлэг мөргөжил, үйлдвэрлэлийн дадлагыг дээшлүүлэх, цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга батыг эрс сайжруулах.

—Худалдаа, нийтийн хоолны цэг нэг бүрээс худалдагч, агент, гуанз, хөдөлмөрдөд үйлчлэх ажиллагаанд үндсэн эргэлт гаргаж сайжруулах замаар цэг нэг бүр төлөвлөгөөт үзүүлэлт, уралдаанд авсан үүргийг сар, улирал тутам бүрэн биелүүлэх.

Уг тогтоолоор худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөт зорилтыг давуулан биелүүлж чанарын үзүүлэлтийн шаардлагыг хангасан сумдыг 1974 оны социалист уралдаанд шалгаруулан сум, анги, цэг, ажилтан, ажилчдад дор дурдсан шагнал олгохоор тогтоож ХБҮГ, сумдын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлд даалгахдаа:

а) 1 дүгээр байр 1.Айм-

гийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлийн туг, диплом, 4000 төгрөгөөр

б) 2 дугаар байр 1.Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөлийн диплом, 3000 төгрөгөөр

в) 3 дугаар байр 1.Аймгийн ҮЭ-ийн зөвлөл, ХБҮГ-ын баярын бичиг, 2000 төгрөгөөр шагнах ба 1, 2, 3 дугаар байр эзэлсэн сумдын намын үүр, хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, ҮЭ-ийн зөвлөл, эвлэлийн хороо, ХБА-ийн дарга нарыг тус бүр 400, 300, 200 төгрөгийн үнэ бүхий зүйлээр шагнана.

Мөн 1974 оны социалист уралдаанд хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан худалдааны тэргүүний ажилчин, мэргэжилтэн нарыг дор дурдсан шагналаар шагнахаар тогтоов. Үүнд:

а) 100 давсан хувьтан, байгууллага, хүмүүсийг шалгаруулж гэрчилгээ олгох.

б) 1974 оны социалист уралдаанд тэргүүн амжилт гаргасан 10 хүртэл хүнийг шалгаруулан аймгийн ХБҮГ-ын хүндэт дэвтэрт бичих.

в) Худалдаа бэлтгэлийн 1974 оны төлөвлөгөөт зорилт, уралдааны үүргийг биелүүлэх ажилд идэвх зүтгэл гарган ажиллаж амжилтад хүрсэн нам, захиргаа, ҮЭ, эмэгтэйчүүд, ардын боловсрол, ХАА, ХБ-ийн байгууллагын ажилтан, ажилчин 8 хүнийг шалгаруулж улсын амралтад амруулах;

Уг тогтоолд 1, 2 дугаар байр эзэлсэн суманд сумын хөдөлмөрдчийг худалдаагаар үйлчлэхэд зориулан автолавка машин олгохоор заажээ.

КОММУНИЗМЫН ӨРНИЙ АЖАА

КУРГАН НУТГИЙН СОНИНООС

Тогтоол. (Түрүүч нь
34, 35 дугаарт)

Бид Китовскийн районны сүү, ногооны САА-н үнээний байрыг үзлээ.

Энэ байранд өтгөн шингэнийг дамжуулагч (транспорт) аар биш харин төмөр сараалжаар таглагдсан гүнзгий бетон шуудуунд шууд унах юмуу урсан орж байхаар тохируулан хийж тэр нь 21 метр тутамд гадагшаа гарсан налуу шуудуугаар өөрийн даралтаар урсан гарч байна.

Түүнийг жилд нэг удаа сорогч насос бүхий цэвэрлэгч машинаар сорж аваад талбайд асгаж бордоо болж байна.

Мөн САА-д тэжээл боловсруулах нэгдсэн цех байгуулжээ. Тэжээлийн агуулахын доторхи үндсэн үрт хүчит, багсармал, дарш, өвс, солом өвсний гурил нь тус бүрийн дамжуулагчаар нэг узель дээр төвлөрөн ирж хэржигдэн, зарим нь шингээлэгдэн нэрэгдэж исээд, зохих жороор найрагдаад үнээний байранд ачигдаж байна.

Складын дэргэд өвсний гурил хийх, савлах цех байгуулагджээ.

Боодолтой сүрлийг химийн уусмал бүхий цементэн нүхэнд тодорхой хугацаанд байлгаж зөөлрүүлэн идэнгэтэй болгон малын тэжээлд ашиглаж байна.

Үйлдвэрт удаан жил ажилласан ахмад ажилтнууд, тэргүүний сайчууд, СХ-ийн баатрууд, сурагчдын сурлага, тэргүүний

эцэг эхийн зургийг самбар, үзүүлэнгээр сурталчилж, хөдөлмөрийн алдар, алтан гартан, эх орны дайнд оролцож яваад одоо ажиллаж байгаа хүмүүс, шинийг санаачлагчид, онцгой бүтээл гаргагчид, социалист уралдаанд түрүүлэгч зэргийг зургагтайгаар үйлдвэрийн байрны гадна, дотор, ажлын байранд тавьж сурталчилж байна.

Куртмашин районны СССР-ийн 50 жилийн ойн нэрэмжит Камканы САА-д нарийн ноост хонийг иж бүрэн байр төхөөрөмжид тус бүр 5,0 мянган толгойгоор байрлуулж 11 дүгээр сараас 5 дугаар сарын дунд үе хүртэл байнгын тэжээл маллагаанд байлган төлийг 1 дүгээр сард (эрт) үйлдвэрлэлийн аргаар бойжуулдаг ажээ.

Шадринскийн районы Хөдөлмөрийн гавьяаны удаан тугийн одонт «Улаан-од» САА-д гахайг үйлдвэрийн аргаар үржүүлж, тэнд аж ахуйн бүрэн тооцоо нэвтрүүлжээ.

Мөн аж ахуйн дунд сургуулийн музейг сурагчид нь хэсэгчлэн тайлбарлаж байна. Музейд харуулсан зүйл нь зөвхөн САА-нхаа үйл ажиллагаа, хөгжиж ирсэн түүх, одоо ба ирээдүйн төлөв, тэргүүний хүмүүсийн хөдөлмөрийн баатарлаг уламжлалыг хойч үедээ загтамдуулж байгаа байдлыг яруу тод харуулжээ.

Аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн дарга Н.ШАГДАРДАГВА

ЧАНАР САЙТАЙ ТУШААВ

Алтанбулаг сумын Алтан-овоо бригадын хоньчин И. Батсүх, Г. Жигмэддорж, А. Дорж, А. Дугар нарын суурь ямааны ноолуурын төлөвлөгөөг 80 хувийн ноолуураар 100—109,5 хувиар биелүүлж бусдыгаа хошууцилж явна.

Энэ бригад 1175 кг ноолуур бэлтгэхээс 42,3 хувийг сайн чанартай тушааж бэлтгэх ноолуурын 80 хувийг Майн баярын өмнө тушаав.

Н. СОДОВ

МАЛ БЭЛТГЭЛ

Д.ГОНЧИГ (Аймгийн Намын хорооны товчооны гишүүн, ХБҮ газрын дарга)

Мал бэлтгэлийн ажил нь улсын төвлөрсөн төлөвлөгөөт бэлтгэлийн дотор чухал суурийг эзэлдэг улс ардын аж ахуйн томоохон зорилтын нэг мөн.

Мал бэлтгэх ажлын талаар нам, засаг удаа дараалан олон чухал арга хэмжээ авч байна.

МАХН-ын Төв Хорооноос мал тууварчдын тэргүүний сайчуудын улсын III зөвлөлгөөний 1975 онд хийлгэх тухай чухал шийдвэр гаргалаа.

Бүх ард түмний социалист уралдааны жил-1973 онд мал бэлтгэлийн төлөвлөгөөг аймгийн хэмжээгээр бүрэн биелүүлсний дотор Сэргэлэн, Эндөрширээт, Эрдэнэ, Эрдэнэсант зэрэг олонхи сумд хугацаанд нь биелүүлж сайхан амжилт гаргасан юм.

Гэвч улсын мал бэлтгэлийн ажлын заавар, стандартыг зөрчиж энэ ажилд тавих хяналтыг сулруулсан ноцтой дутагдал Дэлгэрхаан, Бүрэн, Өнжүүл сумдад гарчээ.

Эдгээр сумд мал хүлээн авах бэлтгэл ажил хөдөлмөрийн зохион байгуулалтыг муу хийснээс хөдөлмөрчид, малчдыг хүлээгдүүлэн чирэгдүүлэх, жинд хүрэхгүй жижиг мал, хээлтэй ба өвчтэй, туувар даахгүй туранхай мал хүлээн авч улсад хохирол учруулж байжээ.

Мөн мал бэлтгэлийн улсын төлөвлөгөөг Дэлгэрхаан, Заамар сумд 3—6 хувиар таслаж төлөвлөгөөний сахилга батыг ноцтой зөрчжээ.

Иймд мал бэлтгэлийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж дээрхи дутагдлыг давтан гаргахгүйгээр энэ оны мал бэлтгэлийг 5 дугаар сарын 15—25-ны дотор зохион явуулж 9243,0 тонн буюу 160,0 орчим мянган толгой мал бэлтгэж нийлүүлэх чухал зорилт тавигдаж байна.

Мал бэлтгэлийн талаар гарсан МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг нарийн чанд мөрдөж мал хүлээн авах, тууварлах ажлыг шуурхай зохион байгуулж ХАА-н нэгдэл, САА, улсад мал нийлүүлэх үүрэг бүхий иргэд, нэгдлийн гишүүдээс бэлтгэлд нийлүүлэх малыг урьдчилан шалгаж соргог сайн бэлчээрт гарган тарга хүч, хүндийн жин сайтай цөөн тооны малаар төлөвлөгөөг биелүүлбэл зохино.

Мал бэлтгэлийн төлөвлөгөөг төрөл бүр дээр нь аж ахуйн сектор бүрээр

биелүүлэх боломжийг найдвартай судалж зохицуулах талаар сумдын комисс тодорхой ажил хийх хэрэгтэй. Мал хүлээн авах хашаа, пүү, тамга, тэмдгийг хүрэлцээтэй бэлтгэж тууврын замыг шалган үзэж, туршлагатай сайн тууварчдыг орон нутгийн нам, улсын байгууллагын хяналтын дор сонгон авч гэрээ хийх, тууварчдыг уналга хөсөг, орон сууцаар хангахад ХБ-ийн анги, ХАА-н нэгдэл, САА-нууд тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй.

Бэлтгэлд дундаас доош тарга хүчтэй буюу жижиг мал олноор нийлүүлэх нь мал өсгөх төлөвлөгөөний биелэлтэнд муугаар нөлөөлөхийн хамт муу чанарын мал бэлтгэснээс улс, аймгийн махны нөөц алдагдахад хүргдгийг ХАА-н байгууллагууд анхаарвал зохино.

Мал бэлтгэлийг зарим сумдын комисс, малын эмч, ХБ-ийн ангийн нөхдийн

хариуцлага сулыг далимдуулан зальт этгээдүүд хуйвалдан хуурамчаар мал тушааж улсыг хохироож байсны гадна хээлтэй, өвчтэй туранхай мал бэлтгэгдэж улсад хохирол учруулж байсан баримт Бүрэн зэрэг суманд гарч байсныг анхаарч ардын хяналтын болон хуулийн байгууллагуудаас тавих хяналтыг хүчтэй болгох хэрэгтэй.

Энэ онд тус аймгаас улсын бэлтгэлд нийлүүлэх мал нь 160 гаруй суурь болон 480 гаруй тууварчидтайгаар тууврын замд гарах ёстой.

Иймд мал тууврын замын дагуу байгаа сумдын нам, улс, ХБ, мал эмнэлгийн байгууллагууд өөрийнхөө сумын нутгаар явж байгаа улсын бэлтгэлийн мал түүний тууварчдад эмнэлэг, үйлчилгээний тусламж үзүүлэн халамжилж ажилд нь хяналт тавьж ажиллавал зохино.

БИРИЙН ТӨЛӨӨ

Хурдан, тэрэгний дав-
хиагаар тэрүүхэн дээгүүр
гарахад хүрэгтэн цэнхэр-
тэх уулсын шовх орой өн-
дөлзөн заримдаа эх газ-
раас салж хийд тогтсон
мэт үзэгдэн наанах их
шар талын дунд бэлчээр-
лэх сүрэг мал хэдэн хувь
өндөр болон сүглийгээд
зурвас мэлцийсэн толин
цэнхэр угсан дээгүүр хө-
дөг онгоц еөд сөөргөө
туучих мэт хаврын зэрэг-
лээнд хачин сониноор
дүрслэгдэнэ.

Нөхөр маань «энэ нут-
гийн сайхан эндээс эхэл-
дэг юмдаа» гээд зогслоо.

Машин зогсохын бараа-
наар бэлчээрийн зүгээс
морьтой хүн айсуу хараг-
дав. Дөхөж ирэхэд нь үз-
вэл Угтаалцайдам сумын
тэмээчин Жамсран гуай
мөн. Ийм сайхан нутгийн
тэмээчинтэй тэр тусмаа
тэмээгээ хариулж явахад
нь уулзсан минь уран зур-
гийн үзэсгэлэнд орсон мэт
сэтгэлд нэг л сайхан.

Жамсран гуай гэж өт-
лөхийн шинж орж яваа ч
гэсэн төрлөхийн ажигч
гярхай нүдээр аливааг
нэвт шувт ажиглан ухаар-
сан хүрэн бор өвгөн мо-
ринхоо цулбуурыг тав-
шуурдан суугаад чулуун
хөөргө гарган тачилав.

Энэ хүнтэй би хэдэнтэй
уулзан учирсан болохоор
танилын халуун яриа дэл-
гэлээ.

Хангай нутагт тэмээ
маллахын эрдмийг энэ л
хүнээс суралтгай санагда-
ла. Тэр зун Бүрдэнд зүсч
байхад нь суралгасаар
хүрч очвол Жамсран гуай
нэг хөөрхөн хүрэн тайлаг
унаад, ширээ улаан ат уна-
сан хөгшнөөрөө хөтлүүл-
чихсэн явж байж билээ.

—Өвгөөн яаж байгаа нь

энэ билээ гэхэд;

—Тэмээн дээрээс тэн-
гэр ойрхон, аймхай бо-
лоод л энэ байхгүй юу
гэж алиалаад тэмээ гэдэг
чинь нүдээрээ ухаардаг
амьтан. Дүрлэгэр том нү-
дий нь хараад түүний зов-
лон жаргалыг ойлгож ч
болмоор санагддаг юм.

Энэ яриаг сонсоод «Хуу-
рын эгшгээр тэмээ үй-
лүүж болно гэж монгол-
чуудын ярьдаг нь талаар
бус» гэж бичсэнийг нэхэн
санавал аргил борил энэ
амьтны нэгэн нарийн увьд-
сыг улам ч тодруулах
бизээ.

Энэ удаа Жамсран гуай
бэлчиж яваа тэмээдийн

ЭРДЭНЭТ МАЛ, ЭРДЭМТ МАЛЧИН

зүг зааж өнгө зүс сайтай
бие чац томтой сайхан
тэмээтэй болж гэвэл буу-
раа сонгож тавихаас эх-
лэн олон зүйлийг анхаар-
рах хэрэгтэй.

Туг ширээ бөхтэй, гүн
улаан зүстэй, мах чамбай,
зогдор өтгөн, ааш аран-
шин зөөлөн ийм тайлаг-
наасаа шилж буураа тавь-
даг. Ингэ хээлтүүлгийн
цаг болоод ирэхлээр би
нутаг сэлгээд байхыг
нэг л таашаадаггүй.

Ингийг хээл авсан да-
руй тэр нутаг усанд нь
ширүүн туулгүй, үргээж
почоолгүй ая зөнгөөр нь
маллавал ингэ бүрээсээ
богто авч болно.

Тэмээ гэдэг амьтан бу-
сад малыг бодвол бие
чац томтой мөртлөө нэ-
зэг турьхан, хаа газрын
бэлчээр ус давын өмнө
тохирдоггүй арчилахад
ажил ихтэй мал гэж би
санадаг шүү.

Ахмадын алтан сургаал

Ялангуяа ботгоны ар-
чилгаа маш нарийн. Эхээс
гарахдаа салхи залгивал
бүтэж үхэх аюултай тул
битүүлж авахаас эхлээд
шар тостой улаан давс-
тай хар цай өгч зунга-
гийг нь гурван хоногт нь
туух, зулай цоорхой төр-
дөг болохоор зулайвч
нэмнээ хэрэглэх зэрэг
наад захын ажил мундах-
гүй. Уйгагүй ажиллаж
мээ нь эрдэнэт мал маань
өснө. Олон малтай болохын
тулд малаа нарийн мэдэж,
өөрөөр хэлбэл эрдэнэт
мал гэснийг учрыг ухаарах
нь чухал юм даа. Сүү ма-
хыг оруулан үйлдвэрлэж
байгаа гэж дуулсан.

Тэгвэл мал маань тэр
аяараа эрднийн фабрик
байна шүүдээ гэв.

Эрдэнэт мал эрдэмт мал-
чин гэж юутай үнэн үг вэ!
Жамсран гуай энэ бүх-

ингэж нэг ярьж билээ.

—Ахмад бүрийн хэлсэн
арван үгнээс хоёр, нэгийг
нь ажил болгож, арван
буудал нутгаас хоёр, нэ-
гийг нь танин эзэмшээд
байвал сайныг дуулалгүй
ях вэ. Нэгдэл нийгмийн
малыг хатуу гараар эд-
лэх хүн хааяа харагдда-
гийг нуух юун.

Унаар эдэлгээнд багд
нь сургаагүй тэмээ малыг
жилийн жилд бөөн хүчээр
морьдын хурдан, аргамаг
олсны бөхөөр эз дийлэн
ноослож, дараа нь тэр мал
хүний бараа харахаа бай-
даг тал байна.

Бод мал иймэрхүү «зов-
лон» эдэлж байхад бог
малын чих бас хөөрхий
болсон газар байдаг.

Нэгдлийнх гэж нэг им-
нээд, бригадаараа бас нэг
имнээд, суурийн тэмдэг
гэж имнээд чихий нь ёс-
той самалдаг болгож эцэс
сүүлд нь замын хар то-
соор ууц нуруугий нь
буддаг тал ч байна.

Замын хар түрхсэн ноос
ямар ч хэрэгцээгүй шүү
дээ. Ноосны төлөвлөгөө
биелүүлэхгүй байгаагийн
нэг нууц үүнд байгаа юм
биш байгаа даа гэж хэ-
лээд тэмээдийгээ захыг
ширтэн байв. Нээрээ ч
юмыг цэгнэн боддог энэ
өвгөний үгэнд хэн бүхний
анхаарах ёстой зүйлийн
гол байж болох юм.

Унага тугалын уяаг ол-
соор хийж хамар хүзүү нь
тасрах дөхсөн бяруу ту-
гал бишгүй байх юм.

Малчин хүн энэ мэтийн
зүйлийг аахар шаахар
гэлгүй анхаарах хэрэгтэй
гэж өвгөн Жамсран гуай
захиж байна. Хөдөө нут-
гийн «онолч» мэргэн энэ
хүний мал маллах тал бү-
рийн ухаан нь Угтаалцай-
дам сумын малчид төдий-
гүй нийт илгээлтийн эд-
дийн уншин судлах турш-
лагын нэгэн боть мэт са-
нагдана.

Ш. ЦЭРЭНДОО

Галуутайн хоньчин

Алс холын Говь-алтай
нутгаас Баяндэлгэр су-
мны «Хэрлэн баян» нэг-
дэлд малчнаар ажилла-
хаар саналаа илэрхийлэн
ирсэн Ц. Буджав «Галуут»
бригадад 5 дахь хавраа
эрлийз хонь төллүүлж
байна.

Ц. Буджав эрлийз хони-
ноос төл бойжуулах ар-
гыг сайтар эзэмшихийн
тул түүнийг арчилж мал-
лах, төлийг бойжуулах
аргын талаар эрдэмтэд
мэргэжилтнүүдийн бичсэн
зөвлөгөө, тэргүүний мал-
чдын туршлагыг тогтмол
судлан-өөрийн ажилдаа
хэрэглэдэг байна.

Малын тарга хүчинд
онцлон анхаарч жилийн
4 улирлын бэлчээрийг на-
рийн хуваарилан ашиглаж
жилд 20 гаруй удаа ну-
таг сэлгэн оторлож бай-
на. 1972 онд эрлийз эм
хонь бүрээ 66 кг жинд хүр-
гэн таргалуулж сумын
эрлийз хонь таргалуулал-
тын аварга болжээ.

«Баатарын толгой» хэ-
мээх газар хонио төл-
лүүлж байгаа хоньчин
Ц. Буджав төлөө хөрвө-
жилтийн үе шатаар цөөн
цөөнөөр нь таслан эхний
7 хоногт эхтэй нь хамт
нэг тасалгаанд байлган
эхийг нь тэжээж услан
төл цадтал эхийгээ хөхөж
байгаа эсэхийг тогтмол
шалгаж хэвтэрийн нь өглөө,
орой бүр сольж байранд
нь цэвэр агаар оруулж
байна.

Мал тэжээх бэлчээр-
лүүлэх хурга хөхүүлэх ца-
гийн хуваарийг нарийн ба-
римталж төлийн байранд
өвс, хивэг минералын зоо-
дой, давстай ус зэргийг
байнга байлгадаг аж.

Ц. Буджав төл сөнсрө-
хөөс сэргийлэхийн тулд
эхээс нь тусгайлж гаднаа
авч тэжээж услан хавар-
жааныхаа нөөц бэлчээрийг
ашиглаж байна.

М. САМДАН

Чолоологдсон нь 30 жилийн ойд

СЕВАСТОПОЛЬЧУУДЫН ЯЛАЛТ

Эх орны аугаа их дай-
ны жилүүдэд Севастополь
хот, Германы фашистуудын
эсрэг Зөвлөлтийн ард
түмэн, Зөвлөлтийн дайч-
дын явуулсан баатарлаг
үйсний бэлэг тэмдэг
болж байв.

Гитлерчүүд хар тэнгэр-
сийн усан замын том
боомт, эдийн засаг цэрэг,
стратегийн чухал цэг Се-
вастополийг эзлэн авах
түрэмгий төлөвлөгөөгөө
хэрэгжүүлэхийн тулд 72
мянган цэрэг, 2000 орчим
өөрөө явах их буу, мино-
мёт, 3000 орчим пулемёт,
50 гаруй танк 100 шахам
нисэх онгоцтойгоор дов-
толсон юм.

Эх оронч, баатарлаг
уламжлалтай Севасто-
польчууд 1941 оны 10 ду-

гаар сарын 30-наас 1942
оны 7 дугаар сарын 4 хүр-
тэл 250 хоногийн турш
Гитлерчүүдийг төрөлх хо-
тынхоо босгон дээр тог-
тоон барьж байгаад ерөн-
хий дээд командлалын ту-
шаалаар хотыг орхин ухар-
чээ. 1944 оны 4 дүгээр са-
рын 8-нд армийн генерал
Ф. И. Толбухины удирд-
сан Украины 4 дүгээр ар-
мийн адмирал Ф. С. Октяб-
рийн удирдсан Хар тэнгэр-
сийн флот, адмирал
С. Г. Горшковын удирдсан
Азовын флотын дайчид
догомг Перекоп, Сивашийн
орчмоор Крымыг чөлөө-
лөх ялгуусан довтолгоо-
ноо эхлэв.

Зөвлөлтийн дайчид
дайсны «Чулуун фронтыг»
зад татаж, томоохон ху-

чийг нь бут цохин давшиж
Севастополь хотыг бүрэн
чөлөөлөв.

Севастополийг чөлөөлөх
тулалдаан 1944 оны 5 ду-
гаар сарын 9-нийг дуусгал
тавхан хоног үргэлжил-
сэн байна.

Севастополийг чөлөө-
лөх тулалдаанд гарамгай
гавьяа байгуулсан 126
цэрэг эрс ЗХУ-ын баатар
цол хүртэж олон арван
мянган дайчид одон меда-
лиар шагнагджээ.

Севастопольчууд дайнд
нэрвэгдсэн төрөлх хотоо
сэргээн босгож, улаан ту-
гийн одонт, баатар хот
Севастополь өнөөдөр
Крымын аж үйлдвэр,
шинжлэх ухаан, соёлын
томоохон төв болон сүн-
дэрлэж байна.

З. ТӨМӨРЧИР



Жаргалантын САА-и Талбулагийн тасгийн Г. Лув-
сандорж даргатай 2 дугаар бригадын тракторчин
М. Гунаа үр суулгах одор бүрийн нормоо 120—150
хувиар биелүүлж явна.

ЗУРАГ ДЭЭР: М. Гунаа трактортоо үйлчилгээ
хийж байна.

Ш. ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг

Баатарлаг үйлсийн баримтаас

Дэлхийн II дайн бол 1,7 сая хүн ам бүхий 61 улс орныг хамарсан юм. Зөвлөлт-Германы фронтод хоёр талын 190—270 дивиз нэгэн зэргээр тулалдаж байв.

Дайсны 607 дивизийг бут ниргэж алагдсан, шархадсан, олзлогдсон 13,6 сая хүнийг 10 сая нь Зөвлөлт Германы фронт дээр үрэгдсэн билээ.

Дайнд оролцсон бусад орноос илүү их хохирлыг ЗХУ хүлээсэн юм.

Немец-Фашистын булаан эзлэгчид Зөвлөлтийн олон зуун хот, 70 мянга гаруй гацаа сууринг өвдөн бусинуулжээ.

Эх орны дайны жилүүдэд ЗХУ-ын коммунист намын эгнээнд 5 сая гаруй хүн элсэн орж тулалдаанд 3 сая гаруй коммунистууд амь үрэгдсэн байна.

Дайны дараахан намд 6 сая шахам коммунистууд байсны тал хувь нь зэвсэгт хүчинд алба хааж байв. Дайнд ялах эдийн засгийн бааз нь Зөвлөлтийн ар тал байсан бөгөөд дайсныг бут ниргэхэд зориулан 1941 оны 7 дугаар сараас 1945 оны 6 дугаар сар хүртлэх хугацаанд онгоц 108028, танк 95090-ийг үйлдвэрлэжээ. Дэлхийн I дайны үед хаант Орос дөнгөж 1 миллиард 393 сая нүүр тариа бэлтгэж байсан бол ЗХУ-ын хамтрал САА-

нууд зөвхөн 1941—1944 онд 4 миллиард 312 сая нүүр тариа улс эх орондоо нийлүүлэв.

Зөвлөлтийн зэвсэгт хүчин дайны туршид 427 сая их бууны сум, мина, хонгиотой сум 17 миллиард, 13 сая гаруй тонн шатахуун, 40 орчим сая тонн хүнсний зүйл зарцуулжээ.

Холбоотон АНУ, Англи улс Зөвлөлтийн цэргийн үйлдвэрүүдийн үйлдвэрлэж байсантай зэрэгцүүлэхэд тун ялимгүй бага зүйл тухайлбал зенитын зэвсгийн 2 орчим хувь, онгоцны 13 хувь, танкны 7 хувийг нийлүүлж байв.

Эх орны дайны жилүүдэд Зөвлөлтийн хүмүүс нийтээрээ эрэлхэг гавъяа байгуулж 7 сая гаруй хүн засгийн дээд шагнал хүртжээ.

Гарамгай гавъяа байгуулсан 11603 хүн ЗХУ-ын баатар цол хүртжээ.

Эх орны дайны жилүүдэд 300-гаад хүн, А. М. Матрасовын жиншээгээр, 72 хүн инсегэгч Н. Ф. Гастелбийн жиншээгээр тус тус гавъяа байгуулжээ.

Эх орны дайны жилүүдэд хөдөлмөрийн гарамгай гавъяа байгуулсан 191 хүн социалист хөдөлмөрийн баатар, 16 сая хүн одон медалидаар шагнагджээ.

Н. ХАНДСҮРЭН



Хөдөлмөрчдийн хууль
ЗҮЙН МЭДЛЭГТ

СОЦИАЛИСТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭВИЙН АЖИЛЛАГАА

БНМАУ-ын эрүүгийн хуулинд социалист үйлдвэрийн ажиллагааны эсрэг нийгэмд аюултай үйлдлүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тогтоожээ. Үүнд:

Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд үйлдвэрийн газруудаас гологдол буюу стандартыг зөрчсөн үйлдэхүүн гаргагчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Энэ үйлдэл нь эд материалыг гарздаж, ажилчдын хүчийг үр ашиггүй зарцуулж улсын төлөвлөгөөний биелэлтийг тасалдуулж нийгэм ба манай иргэдийн эрх ашигт ноцтой хор хохирол учруулдаг юм.

Иймээс энэ гэмт хэрэг нь үйлдвэрийн газрын хэвийн ажиллагаа, улс ба иргэдийн хэрэгцээний эсрэг чиглэсэн объектай байдаг.

Харин зэрэг дугаар буурсан бүтээгдэхүүн нь нэмэгдэл ажиллагаа шаардахгүйгээр хэрэглэдэг тул гологдол үйлдэхүүнээс өөр ойлголт юм.

Зэрэг дугаар бууруулах

нь материалыг бүрмөсөн устгаагүй, ажиллагчдын хүчийг ашиггүй зарцуулаагүй зөвхөн үйлдвэрийн ашигтай ажиллагаанд муу нөлөө үзүүлдэг учраас захиргааны хариуцлага хүлээлгэдэг юм.

Ямар нэгэн таворын улсын стандарт бол уг бүтээгдэхүүний техникийн нөхцөл, яс чанарын байдал, эдэлгээний журмын үзүүлэлтүүдийг төрийн байгууллагаас урьдчилан тогтоосон эрхийн хэм хэмжээ юм.

Улсын стандарт зөрчсөн үйлдэл бүрийг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Гагцхүү стандарт зөрчсөнөөс улс ба хэрэглэгчид дэд хохирол учруулсан бол гэмт хэрэг болно.

Эрүүгийн хуулийн 117 дугаар зүйлд заахдаа:

Үйлдвэрийн газраас гологдол буюу батлагдсан стандарт, техникийн нөхцөл тохироогүй, бүрэлдэхүүн хэсгүүд нь гүйцэт биш үйлдэхүүнийг удаа дараа буюу их хэмжээтэйгээр гаргасан үйлдвэрийн дарга, ерөнхий инженер, эд шалгах хэлтсийн дарга түүнчлэн эдгээр тушаалын үүрэг гүйцэтгэж байгаа бусад хүмүүсийг 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал гүйцэтгэх эрхийг хасах буюу олон нийтийн өмнө бууруушаана гэжээ.

Энэ зүйлд заасан гологдол ба стандарт зөрчсөн үйлдэхүүн гаргах гэмт хэрэг нь зөвхөн үйлдвэрийн газраас гаргасан үйлдэхүүнд хамаарна. Гологдол буюу стандарт зөрчсөн үйлдэхүүнийг захиалагчид шилжүүлэхээр албан ёсоор батал болгосон үед гэмт хэргийн бүрдэл төгссөн гэж үзнэ.

Иймээс гологдол ба

Б. ЖУНАЙ

стандарт зөрчсөн үйлдэхүүнийг үйлдвэрлэн байх үед нь илрүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй юм.

Мөн энэ зүйлд зааснаар ийм бүтээгдэхүүн ганц нэг тохиолдолд үйлдвэрлэсэн бол энэ нь гэмт хэрэг биш, харин ганц удаа үйлдвэрлэхдээ их хэмжээтэй үйлдвэрлэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээх учиртай (117 дугаар зүйлийг унш).

Энэ хэрэг нь тусгай субьекттой (хүн бүрээр үйлдэгдэхгүй) зөвхөн үйлдвэрийн дарга, түүнчлэн эдгээр тушаалыг үүргийг гүйцэтгэж байгаа хүмүүст л хамаарагдана.

Эрүүгийн хуулийн 118 дугаар зүйлд муу чанарын буюу батлагдсан зураг төсөлд тохирохгүй, түүнчлэн барьж дуусаагүй үйлдвэрийн ба аж ахуйн бусад барилга, төхөөрөмж, орон сууцны байшинг ашиглалтанд оруулахаар хүлээлгэн өгөх буюу хүлээн авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тогтоосон байна.

Энэ гэмт хэрэг бод манай их барилгын үйлдвэрийн хэвийн ажиллагааны эсрэг чиглэсэн объектай байдаг.

Эл хэргийн улмаас улс нийгмийн хөрөнгө, хүмүүсийн эрүүл мэнд, амь нас, тэдний амьдралд ноцтой хор хохирол учирч болзошгүй байдлыг төрүүлдэг юм.

Муу чанарын барилга барьсан гэмт хэргийн бүрэлдэхүүн нь муу чанарын барилга барьж дууссан, батлагдсан зураг төслийг зөрчсөн барилга барьсан, эсхүл барьж дуусаагүй барилгуудыг ашиглалтанд оруулахаар хүлээлгэн өгсөн буюу хүлээн авснаар гэмт хэргийн бүрдэл төгссөн.

Муу чанарын барилга барих нь санаатай ба болгоомжгүйн аль ч хэлбэртэй байж болно.

Тэгэхдээ улсын эдийн засгийн хүчин чадлыг сулруулах, хорлон сүйтгэх зорилготой байна.

Уг хэргийг үйлдсэн этгээдийг 3 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэх, эсхүл нэг жил зургаан сар хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял оногдуулахаар заажээ.

Өсвөрийн дугуйчдын уралдаан болов

МХЗЭ-ийн Төв Хороо, Монголын Пионерийн төв зөвлөлийн хэвлэл «Залгамжлагч» сэтгүүлийн нэрэмжит өсвөрийн дугуйчдын уралдаан Зуунмод хотод болов.

Өсвөрийн дугуйчдын уралдааныг 1970 оноос эхлэн явуулах болсон бөгөөд энэ уралдааны нэрэмжит цомыг сүүлийн 2 жил дараалан тус аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн баг тамирчид хадгалж ирсэн юм.

Дугуйчдын энэ уралдаанд нийслэлийн 24, 12, 28, 3, 5, 47, 21, тус аймгийн Жаргалант, Батсүмбэр, Налайх хотын 8, 10 жилийн дунд сургуулиудын 79 охид хөвгүүд 2, 4, 5, 10 км-ийн зайд хүчээ сорив.

Охидын 2 км-ийн уралдаанд Батсүмбэрийн 8

жилийн дунд сургуулийн сурагч Оюунцэцэг 3 минут 25, нийслэлийн 12 дугаар сургуулийн сурагч Дагиймаа 3 минут 32, Батсүмбэрийн 8 жилийн сургуулийн сурагч Оюундэлгэр 3,35 секунд хурдалж 1, 2, 3 дугаар байр эзлэв.

Хөвгүүдийн 4 км-ийн зайд 29 тамирчин орсноос 24 дүгээр сургуулийн Энхболд 8 минут 16 сек, 14 дүгээр сургуулийн Чулуунбат, нийслэлийн 21 дүгээр сургуулийн сурагч Бат-Эрдэнэ нар дараах байранд оров. Охидын 5 км-ийн зайд 28 дугаар сургуулийн Хишигбат 11 минут 47, 21 дүгээр сургуулийн Тунгалаг 13,25 секундээр 1, 2 дугаар байр эзэллээ.

Хөвгүүдийн 10 км-ийн уралдаанд 30 шахам та-

мирчид оролцсоноос нийслэлийн 12 дугаар сургуулийн сурагч Ганболд, төвийн 10 жилийн сургуулийн сурагч Түмэн-дэмбэрэл, Даваацэрэн нар тэргүүн байранд оров.

Багийн нийлбэр дүнгээр 10 жилийн сургуулиудын дотроос нийслэлийн 12 дугаар сургууль 1 дүгээр байр, төвийн 10 жилийн сургууль, Жаргалантын 10 жилийн сургуулиуд дараах байрыг авлаа.

8 жилийн сургуулиудын дотроос Батсүмбэрийн 8 жилийн дунд сургууль тэргүүн байранд оров. Түрүүлсэн баг тамирчдыг шилжин явах цом, диплом, «Пионерийн үнэн» сонинны 30 жилийн ойн медаль, үнэ бүхий зүйлээр шагнав.

Д. ДЭМБЭРЭЛ



Дугуйчид гараагдана

Л. Дамдиндоржийн авсан гэрэл зураг

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Архустын сургууль комбинатын тракторчин н. Пүрэвжал нь иргэний 308319 тоот үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.